



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/35

Улаанбаатар хот

Ажлын цагт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар баталсан Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бага насны болон цэцэрлэг, сургуулийн хүүхэдтэй албан хаагчдын ирүүлсэн хүсэлтийг үндэслэн ажлын цагийн уян хатан нөхцөлийг бүрдүүлэх, хүүхдээ цэцэрлэг, сургуульд нь хүргэж өгөх, авах боломжоор хангах зорилгоор албан хаагчдын ажлын цагийн хуваарьт хавсралтад дурдсаны дагуу өөрчлөлт оруулсугай.

2. Албан хаагчдын ажлын цагийн өөрчлөлтийг бүртгэлийн программд тохируулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Д.Ганболд)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн аялал жуулчлалын газрын даргын
2024 оны... дугаар сарын...-ны өдрийн...
дугаар тушаалын хавсралт

АЛБАН ХААГЧДЫН АЖЛЫН ЦАГИЙН ХУВААРЬ

	Овог нэр	Албан тушаал	Цагийн хуваарь
1	2	3	4
1	Д.Ганболд	Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга	07.00-16.00
2	О.Нямбат	Бодлогын баримт бичгийн тайлан, тогтоол шийдвэр, үйл ажиллагааны хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн	07.00-16.00
3	Ш.Ундармаа	Хүний нөөц, ёс зүй дотоод ажил хариуцсан мэргэжилтэн	07.00-16.00
4	Ч.Энх-Отгон	Сургалт, судалгаа, хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн	07.00-16.00
5	Д.Оюун-Эрдэнэ	Аялал жуулчлалын байгууллагууд, үйлчилгээний чанар, стандарт хариуцсан мэргэжилтэн	07.00-16.00
6	Д.Долгоржав	Архив, бичиг хэргийн эрхлэгч	07.00-16.00
7	С.Туул	Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга	08.30-17.30
8	Б.Үржинханд	Эвент хариуцсан мэргэжилтэн	07.15-16.15
9	Т.Батдорж	Эвент хариуцсан мэргэжилтэн	07.00-16.00
10	Б.Отгонбилэг	Аяллын бүтээгдэхүүний хөгжүүлэлт хариуцсан мэргэжилтэн	07.00-16.00
11	Д.Сайханчимэг	Гадаад хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн	07.00-16.00
12	Г.Батхишиг	Хөгжлийн бодлого төлөвлөлт, төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн	08.30-17.30
13	Б.Энхцэцэг	Мэдээлэл, сурталчилгааны хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	08.30-17.30
14	Б.Цолмонгэрэл	Хэвлэл мэдээлэл, олон нийтийн харилцаа хариуцсан ахлах мэргэжилтэн	07.00-16.00
15	Б.Энхтайван	Цахим хөгжүүлэлт, мэдээллийн технологи хариуцсан ажилтан	07.00-16.00
16	Б.Мичидмаа	Жуулчны аюулгүй байдал, мэдээллийн төвүүд хариуцсан менежер	07.00-16.00